

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017.10.25

Тендер шалгаруулалтын нэр: *Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих Чингэлтэй дүүргийн 7, 12 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хорооны цахилгаан хангамжийн ажил /Улаанбаатар/*

Тендер шалгаруулалтын дугаар: ЭХА-2017/05-43

Эрчим хүчний яам нь эрх бүхий тендерт оролцогчдоос *Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих Чингэлтэй дүүргийн 7, 12 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хорооны цахилгаан хангамжийн ажил /Улаанбаатар/, ЭХА-2017/05-43*-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **150,000** төгрөгөөр худалдан авч болно.

Төрийн сан банкин дахь Эрчим хүчний яамны 100900030003 тоот дансанд тушаана.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: *Сүүлийн 2 жилийн аль нэг жилд хийж гүйцэтгэсэн ажлын борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй дүнгийн 100 хувиас багагүй байна.*

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: *Тухайн багцын төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна.*

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: *Сүүлийн 2 жил “2015, 2016”*

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

- *Эрчим хүчний сайдын “03.2.2: 0.4-15кВ-ын цахилгаан түгээх шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ”*
- *03.9.3: Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг, төсөл боловсруулах 0.4-35 кВ эсхүл 1.2.5 Дотор гэрэлтүүлэг цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10 кВ хүртэл) тусгай зөвшөөрөлтэй байна.*

Тендерийн хамт 2,010,000 төгрөгний дүнтэй тэнцэх тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг *2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 10 цаг 00 минутаас* өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг *2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн, 10 цаг 50 минутад* нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

17060 Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг.
Чингисийн өргөн чөлөө. Эрчим хүчний яам.
Засгийн газрын ХИҮ байр. 3 давхар. 306 тоот өрөө.
www.energy.gov.mn